

## Ядуусын төлөөх хөгжил гэж юу вэ?

*Д.Энхзаяа, МУИС-ийн ЭЗС-ийн эдийн засгийн онол, 3 курс, оюутан*

Өнөөдөр монголын нийт хүн амын гуравны нэг орчим хувь нь ядуу амьдарч байгаа бөгөөд энэ нь хүнсний болон хүнсний бус наад захын хэрэгцээг хангаж чадахгүй байдлаар тодорхойлогдож байна. Ямар ч үзүүлэлтийг авч үзсэн үнэндээ улс орны өмнө тулгарч буй ядуурлыг бууруулах асуудал чухал болоод байна.

Өрх толгойлсон эмэгтэйчүүд, олон хүүхэдтэй айл өрх болон хот суурин газар амьдардаг айл өрхүүд илүү ядуурах магадлалтай байна. Хот суурин газрын ядуурал нэмэгдэж байгаа нь хөдөө орон нутгаас хот руу чиглэсэн хүн амын шилжих хөдөлгөөн өсч байгаатай холбоотой юм. Ядуурлаас болж гэмт хэрэг нэмэгдэх нийгмийн сөрөг үзэгдлүүдийг бий болгож байна.

Ядуурал гэдэг нь зөвхөн орлого буюу хэрэгцээ хангалтгүй байхыг хэлэхгүй ажилгүйдэл, боловсрол, эрүүл мэнд, гэр бүлийн хүчирхийлэл болон архидалтын улмаас хувь хүний өөртөө итгэх итгэл алдрах, өөрийгөө болон бусдыг үл хүндлэх асуудалтай нягт холбоотой юм. Судалгаанаас үзэхэд нэн ядуу иргэдийн гуравны нэг нь ажилгүй байна.

Монголын засгийн газар нийгмийн эмзэг

ядуу хэстгийнхийг дэмжихэд чиглэсэн нийгмийн халамжийн бодлогод анхаарч, ядуурлыг бууруулахад чиглэсэн эдийн засгийн өсөлт, тэднийг хөгжүүлэх талын бодлогыг орхигдуулжээ. Ядуу хүмүүс зөвхөн эдийн засгийн өсөлтийн үр шимийг хүртэгчид бус түүнд хувь нэмрээ оруулж чаддаг байх нь чухал билээ.

Манайд зөвхөн ажлын байрыг бий болгосноор ядуурлыг бууруулж чадахгүй нь тодорхой байна. Үүний тулд засгийн газар хөдөлмөр эрхлэлтийг дэмжихдээ капитал зарцуулалт ихтэй ажлын байрыг бий болгох бус хөдөлмөр зарцуулалт ихтэй үр чадвар бага шаардах, ядуу хүмүүсийг өрсөлдөн ажиллах боломжтой салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих хэрэгтэй.

Нийгмийн эмзэг бүлгийхний дунд бусдын гарыг харж суудаг сэтгэлгээ багагүй байгаа бөгөөд юуны өмнө үүнийг өөрчлөх нь чухал юм. Тиймээс тэднийг тусгайлан анхаарч халамжлах бус харин идэвхжүүлж, чадавхжуулах шаардлагатай. Ядуусын амьжиргаагаа дээшлүүлэх гэсэн эрмэлзлэлийг тал бүрээр дэмжих, мэдлэг чадвар эзэмшүүлэх, тэдэнд өөртөө итгэх итгэлбий болгох нь нөөцийн хуваарилалтаас ч илүү ач холбогдолтой юм.